

№ 1445



“ЭРДЭНЭС ТАВАН ТОЛГОЙ” ХК-Д

**МОНГОЛ УЛСЫН
БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Нэгдсэн Үндэстний гудамж 5/2, Засгийн газрын II байр,
Утас: 26 19 66, Факс: (976-51) 26 61 71,
И-мэйл: contact@mne.gov.mn, Вэбсайт: www.mne.mn

2019.09.25 № 06/6673
танай _____-ны № _____-т

Зөвлөмж хүргүүлэх тухай

Танай байгууллага 2019 оны 09 дүгээр сарын 19-нд “Эйр кондейшн нийлүүлэх” тендер шалгаруулалт зарласан байна.

Энэхүү эйр кондейшн нь Монгол улсын 1996 онд нэгдэн орсон Озоны давхаргыг хамгаалах Венийн конвенц, Озоны үе давхаргыг задалдаг бодисын тухай Монреалийн протоколыг хэрэгжүүлэх зорилгоор озон задалдаг бодисыг үе шаттай бууруулах шаардлагыг хангасан озон-уур амьсгалд буюу байгаль орчинд ээлтэй хөргөх бодис ашигласан байх шаардлагатайг тендер шалгаруулахдаа анхаарна уу.

Уг конвенц, протоколд нэгдэн орсон Тал-Улс орнууд озон задалдаг болон дэлхийн дулааралд нөлөөтэй хүлэмжийн хий бүхий хөргөх бодисын үйлдвэрлэл, импорт, экспорт, хэрэглээг үе шаттай бууруулж, цаашид 2030 он гэхэд олон улсын гэрээгээр эдгээрийг бүр мөсөн хэрэглээнээс гаргах юм.

Иймд худалдан авалтын хүрээнд тендерийн баримт бичигтээ тодотгол хийж, HCFC-22, HCFC-123, HCFC-142b болон HCFC-22 бодис агуулсан бусад хольц (HCFC blends), бүхий хөргөх байгууламжийн технологийн тоног төхөөрөмж, хэрэгслийг худалдан авахгүй, Техникийн тодорхойлолтын үзүүлэлтэд энэ төрлийн бодисыг оруулахгүй байхыг зөвлөмж болгож байна.

Дээр дурдсан хэрэгцээ, шаардлагуудад үндэслэн дараах мэдээ, мэдээллийг хавсралтаар хүргүүлж байна.

ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН, БАЙГАЛИЙН
НӨӨЦИЙН УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГА П.ЦОГТСАЙХАН
1119278525 43995884

[Handwritten signature]

2019.09.30

[Handwritten signature]
Хүрэг хүргүүлсэн
2019.10.1

026129

Худалдан авалт хийхэд анхаарах озоны давхарга болон уур амьсгалын өөрчлөлтөнд сөрөг нөлөөгүй технологийн сонголтууд

ГХФН-д (HCFC) хөргөх бодист суурилсан тоног төхөөрөмж/систем болон энэхүү бодисуудыг орлуулахад ашиглаж буй эрчим хүчинд хэмнэлттэй, озон задлах болон дэлхийн дулааралд нөлөөлөх чадваргүй эсвэл дэлхийн дулааралд нөлөөлөх чадвар хамгийн багатай бодисуудын жагсаалт:

1.	<p>Ахуйн зориулалттай хөргөлт, агааржуулалт</p> <ul style="list-style-type: none"> • R-600a (изобутан) • HC-290 (нүүрсустөрөгчүүд) • Дэлхийн дулааралд үзүүлэх нөлөө багатай HFC хөргөх бодисууд. Жишээлбэл: R-32 болон бусад дэлхийн дулааралд үзүүлэх нөлөө багатай хольцууд • HFO-1234yf, бусад ханаагүй фторт химийн бодисууд болон тэдгээрийн хольцууд.
2.	<p>Худалдааны зориулалттай хөргөлт, агааржуулалт</p> <ul style="list-style-type: none"> • Нүүрсустөрөгчүүд—изобутан (R-600a), пропан (R-290), and пропелин (R-1270) • Аммиак (R-717) • Нүүрсхүчлийн хий (R-744) • Дэлхийн дулааралд үзүүлэх нөлөө багатай HFC хөргөх бодисууд. Жишээлбэл: R-32 болон бусад дэлхийн дулааралд үзүүлэх нөлөө багатай хольцууд • HFO-1234yf, бусад ханаагүй фторт химийн бодисууд болон тэдгээрийн хольцууд.
3.	<p>Хөөсрүүлэгч бодисууд:</p> <ul style="list-style-type: none"> • Циклопентаны хольц • HFO-1234ze болон бусад HFO-ын хольц • Диметоксиметан • Метил шоргоолжны хүчил
4.	<p>Барилга/дулаалгын хөөсөнцрийн хэрэглээ:</p> <ul style="list-style-type: none"> • Нүүрсустөрөгчүүд (циклопентан, циклопентаны хольц, изобутан, n-пентан) • Нүүрсхүчлийн хий • Диметилийн эфир (Di-methyl Ether) • Метил шоргоолжны хүчил • Диметоксиметан • HFO-үүд (HFO-1234ze болон бусад)
5.	<p>Цахилгаан, дулааны аргаар хөргөх:</p> <ul style="list-style-type: none"> • Нарны эрчим хүч ашиглах хөргөлт, агааржуулалтын систем • Цахилгаан, дулааны аргаар хөргөх, орчноор хөргөх (орчны дулаан, хүйтнийг ашиглаж хөргөх, гадна, дотно орчны температурын ялгавараар ажилладаг) г.м. • Дангаар суурилуулдаг худалдааны хөргөх төхөөрөмж